

Японы уран зохиолд тусгагдсан монголчуудын тухай

Ютака Шибияама
Япон. Сэйсан Жогагүйн Их Сургууль

Энэ удаа Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуультай холбоо харьцаатай болсонтой уялдуулан Сургуулийн зүгээс ямар нэг сэдэвтэй илтгэл тавьж өгөөч гэж санал болгосны дагуу өнөөдөр ‘Японы уран зохиолд тусгагдсан монголчуудын тухай’ гэсэн сэдвээр илтгэл тавья гэж бодож байна. Монголын эрдэмтэдэд хандаж монголын уран зохиолын тухай ярихаас зайлсхийн японы уран зохиолын тухай ярьж бодно. Мэдээж японы уран зохиолын судлаачдаас арай өөр, монголын судлаачийн үүднээс ярих болно. Монголын уран зохиолын тухай миний судалгаа бол Д.Нацагдоржийн судалгаа, монголын орчин үеийн уран зохиолын түүх, Ариун библийн номын орчуулагын судалгаа зэрэг хэл бичгийн ухааны судалгаанаас гадна ‘Хүлээн авалтын онол(受容理論)’, монголтой холбогдох японы ориентализмын судалгаа гэх мэтийн пост-модернийн арга зам хэрэглэдэг судалгаа болно. Өнөөг хүртэл явуулж ирсэн судалгаагаараа дамжуулан олж мэдсэн японы уран зохиолын бүтээлүүдэд тусгагдсан монголчуудын талаар ярьсаны дараа та бүхэнтэй саналаа чөлөөтэй сольж чадвал улам үр өгөөжтэй болов уу гэж бодож байна. За, тэгвэл гол сэдэвдээ орё. Юаны дээрэмчид гэсэн түүхт хэрэг Японы түүхэнд их нөлөө үзүүлсэн боловч Эдогийн үе хүртэл ‘Монгол’, ‘Мооко(蒙古)’ гэсэн нэрийг энгийн ард иргэд мэдэхгүй байжээ. Энэ гэрчээр Эдогийн үед Орост туугдан хөвсөн Даикокуяа Коодаюү(大黒屋光太夫)-гээс тэмдэглэн авсан “Хокүса-бүнриакү(北槎聞略)”-д(1794) ч ‘Монгол’ гэсэн үг харагдаагүй байна. ‘Мооко’, ‘Монгол’ япончуудад ойр дотно болж эхлэх нь Мэижи(明治)-гийн үеээс хойш явдал болно. ‘Монгол’ гэсэн үг нь нэг талаар 19-р зууны үеийн ‘чадалтай нь чадалгүйгээ барьж идэх’ геополитикийн асуудлаар, нөгөө талаар Өрнөдахины Азийн үзлийн нэг хэсгээр Японд орж ирсэн. Энэ хоёр хүчин зүйл холигдож япончуудын монголын үзэл бий болсон байна. Европ хүмүүс Япончуудыг монголойд буюу монгол удамтан гэж үздэгийг Япон хүн өөрөө мэдэх боллоо. Хэрэг дээр нь европойд(цагаан арьстан), негроид(хар арьстан) гэсэн томъёололтой харицуулан үзэхэд монголойд гэж тусгай нэрийдэл бөгөөд Оксфордын ангил хэлний толинд заасанчлан ‘монгол’ гэсэн үг ялгаварлан үзэх утгаар хэрэглэж ирсэн түүхтэй. Улсаа нээсэнтэй зэрэгцээ 19-р зууны Өрнөдахины Азийн үзэлтэй танилцсанаар япончууд ‘монгол хүн’ гэсэн нэрийдлийн утгийг бодолхийлэхээс өөр аргагүй болсон юм. Жишээлбэл Ямажи Аизан (山路愛山,1864-1917) бол Мэижигийн үеийн уран зохиолыг ярихад маш чухал хүн бөгөөд 1914 онд ‘Би монгол удамтан болсноо ичгүүрт үл бодмой’ гэсэн өгүүлэл бичсэн. Түүнээс түрүүлэн 1906 оны нэг номдоо ‘Хятадын үзэл санааны түүхэнд монголчуудын үзүүлсэн гавьяа зүтгэл’ гэсэн нэг бүлэг бичсэн байна. Өрнөдахины дэлхий дахины үзэлтэй ойртон түүнийг шүүмжлэн хүлээн авах явцад японы Азийн үзэл бий болсон бөгөөд энэ явцад чухал үүрэг гүйцэтгэсэн нь “Монголын нууц товчоон” болох юм. Хятадын ерөтөнцийн захад л байсан Японоо гол болгон хаант улс байгуулахын тулд Өрнөдахины түүхийн эсрэгээр ‘Дорнодахины түүх’-ийг бий болгох шаардлагатай байсан билээ. Сонг улсаар дуусдаг

“Арван Найман Түүхийн Товчоон(十八史略)”-ы дараах ‘түүх’-ийг бий болгох шаардлагаар японы монголын судалгаа бий болоход нэгэн түлхэц болсон байна. Нака Мичиёо (那珂通世)-гийн “Нууц товчоон”-ыг орчуулан тайлбарласан “Жингискан жицүрокү (成吉思汗実録)” (Даи-ниппон-тошо, 1907) гарч ирлээ. Нака Мэижигийн үеийн өөрчлөн шинэчлэлтэд ялагдсан талынх Мориока мужийн иргэнийн 3-дах хүүгээр төрж, Мэижигийн шинэчлэлтийн дараа Кэиоогижүкү-гийн Их Сургуульд(慶応義塾) ангилын ухааныг сурсан хүн байна. Фүкүзава Юкичи(福沢諭吉)-гийн шууд нөлөөн доор байсан бөгөөд гадаад түүхийг өрнө, дорнодахинаар хуваасан үзлийн үндсэнд түүний ‘Азиас гарч европт орох(脱亜入欧)’ үзэл байсан гэнэ.

Нака-гийн орчуулсан “Нууц товчоон” өндөр чанараар маш хурдан хэвлэгдсэн нь маш гайхалтай. Энэ ном хэвлэгдсэн цаг хугацаа нь Япон-Оросын дайны дараах Портсмут гэрээнд Солонгос, Лиаодон хойгийн эрх ашгаас гадна Дончиний(東清) төмөр замын өмнөд хэсгийн эзэгнэх эрхтэй болсон Японы хувьд Манжгүодох эрх ашгийг хамгаалах явдал хамгийн чухал асуудал болоод байсан учраас үнэнч шудрага эрдэмтний үг яриа нь төвийг сахиж байсан ч гэсэн Японы төрийн бодлогоос бүрэн чөлөөтэй байж чадаагүй байх.

Энэ Нака Мичиёо-гийн “Нууц товчоон”-ы орчуулага “Жингискан жицүрокү” бол түүхийн ухаан, хэл шинжлэлд ямар ямар нөлөө үзүүлсэнийг өнөөдөр энд хүрэлцэн ирсэн и242 та бүхэний хувьд мэдээж хэрэг засаг нь өндөр өслөлтөд огцом шилжих гэж байсан үе болоод байжээ.

2-р дайны дараах хямралаас гарч шинэхэн Японы ирээдүйн дүрсийг зурах үе болоод байсан юм. Энэ онд Чингис хааны олон өгүүллэгүүд бий болсон явдал ч гэсэн эдийн засгийн хямралын дараах ‘алдагдсан’ 10 жилийг туулан Япон бие даасан улсаар хаашаа явах гэж байгааг ард иргэн эргэлзэж байгаа цаг үетэй холбоотой байж магадгүй.

Мөн энэ өгүүллэг нийтлэгдсэнтэй холбогдон Оока Шоохэи(大岡昇平,1909-1988)-тэй маргалдсан түүхийн өгүүллэгийн маргаанд бас анхаарал тавих хэрэгтэй. Оока-гийн тавьсан асуудал японы уран зохиолын түүхэнд их утга агуулгатай болсон.

Түүх ба уран зохиол гэсэн хэцүү асуудал түр орхиё. “Аоки ооками”-г уншихад зохиолч өөрөө амьдарч байгаа цаг үе болон нийгмийн хам утгаас нь салган өгүүллэг бичиж чадах эсэх гэсэн асуудлыг бодолхийлэхгүй байж болохгүй. Та бүхэн мэддэгчлэн Иноүэ-гийн хувьд Чингис хааны ‘төрөлтийн нууц’ гэсэн ойлгомжтой түлхүүр үгээр өгүүллэг бүхнийг ойлгоход амархан болгосон боловч энэ нь Чингис хааны үеийн монголчуудын сэтгэлийн нийтлэг байдал биш байна. ‘Төрөлтийн нууц’ гэдэг нь японы орчин үеийн уран зохиолд нэг төрлийн ядуу нуршаа үг гэмээр түлхүүр ойлголт байжээ. Чингис хааны төрөлтийн асуудлыг Ралф Фоксын зохиолд ганц үгээр бичсэн байна. Дээр нь Чингисээс өмнөх үед хуралдайн тогтолцоо өөрөө цэвэр цусны удмын үзлээс ерөөс холбогдолгүйн тал нутгийн зарчмыг харуулж байсныг сайн ойлгож байгаад Иноүэ зориуд өгүүллэгийн төвд энэ нууцыг тавьсан юм.

Иноүэ-гийн өгүүллэг бичсэн иймэрхүү аргыг ойлгох битүү дохио бол Хулан Чингист хандаж хэлсэн үгэнд харагдаж харагдаж байгаа биш үү? “Надад өвөрлөж байгаа сэтгэл чинь ‘хайр’ мөн үү?” “Нууц товчоон”-д ерөөс байдаггүй энэ үгийн хачин чанарыг олж мэдэх япон хүн цөөхөн байх. Гэтэл монголын судлаачийн нүдээр үзэхэд

энэ ёстой хачин үг болох юм. Яагаад гэвэл тухайн үеийн монгол хэлэнд ‘хайр’ гэсэн утгатай үг байгаагүй. Үг байгаагүй гэдэг нь ойлголт байгаагүй гэсэн үг. Хэрэг дээр япон хэлэнд ч байгаагүй байх. Иймэрхүү утга бүхий ‘хайр’ гэсэн үг япон, монгол хэлэнд орчин үеэс хойш баруун европын хэлний орчуулагаар бий болсон ойлголт юм. Хэрэг дээр хайр гэсэн ойлголтыг монголоор яаж орчуулах гэсэн маргаан 1950-иад оныг хүртэл үргэлжлэгдсэн байна. Бүгд найрамдах ард улсын үеийн монголын уран зохиолд С. Эрдэнийн бичсэн өгүүллэгт Хулан гэдэг эмэгтэйг гол дүр болгон Чингис хаан гэдэг хоч нэртэй хүн гарч ирсэн бүтээл байхыг та бүхэн мэдэх үү? Чеховийг эрмэлзэж байгалийн шинжлэх ухаанчийн үүднээс сэтгэлийн байдлыг дүрслэхэд маш сайн байсан Эрдэнийн бичсэн хайр дурлалын тууж дотор английн ‘love’ гэсэн утгатай ‘хайр’ гэсэн үг нэг ч удаа гарч ирээгүй. Иноүэ түүхийн монголчуудыг дүрслэх гэж байсан биш, “Нууц товчоон”-ыг ашиглан орчин үеийн зүй зохистой Чингис хааныг дүрслэсэн байна. Мэдээж, тухайн үед монголчуудад бус, япончуудад зориулан бичсэн Чингис хаан байжээ. Иноүэ монголчуудыг шал өөр хүмүүс, ерөөс ойлголцохгүйгээр дүрслээгүй, харин аль болох ойртон өөрийгөөтэй адилтгаж үзэсэн юм. Иноүэ монгол хүний царай гарган бичсэн учир бодьт амьдрал дээрх эвгүй хүчин зүйл, японы маяг, монголын маяг, энэ тэр гэсэн соёлын зөрчилийг арилган бичсэн байна. Сонирхолтой нь тус өгүүллэгийг унших дуртай монгол хүн цөөнгүй байгаа юм. Монгол хүмүүс “Аоки-ооками”-г дуртайяа уншиж байна гэвэл үндэстний үүсэл гарлыг дахин нягтлан үзэх хандлагатай гэж санагдах боловч үнэн дээрээ тэгж хэлж арай болохгүй байх. Монгол хүмүүсийн амьдралын ухамсар нь тус өгүүллэг бичигдсэн 1960-аад оны япончуудын ухамсар, өөрөөр хэлбэл хам утгаас салсан түгээмэл шинжийг олохыг чармайн ухамсараас нэг их зөрөө байхгүй болсон гэсэн үг байна. “Аоки-ооками”-д сэтгэл хөдлөх хятад, монголын уншигчид байна гэдэг нь хятад, монголын онцгой үнэлэмжээс биш, орчин үеийн дэлхий дахинд байдаг түгээмэл үнэлэмжээс гол дүрсийг дэмжиж байгаа юм байна. Эх хувь болох и8220 “Нууц товчоон”-д орчин үеийн хүний бодлыг ойртуулахгүй тал байдаг учраас тийм ч амархан ойлгох ёсгүй боловч “Аоки-ооками” бол олон түмний сэтгэл зүй, хайр дурлал, аль эсвэл үндсэрхэх үзэл гэх мэтийн орчин үеийн аппаратаар орчин үеийн үнэлэмжийн зүгээс үзэхэд япончуудын хувьд ч гэсэн, монголчуудын хувьд ч гэсэн ойлгомжтой болох юм. Төрөлтийн нууцын цаана байгаа цэвэр цусны үзэл ч гэсэн орчин үед шинээр зохион бүтээгдсэн зохиомол уламжлалт гэж хэлж болно. Монгол бол гибрид чанартай багаар Их Монголыг байгуулсан учраас угаас нь явчуу цэвэр цусны үзлээс чөлөөтэй байх ёстой. Чингис хааны ордны хувьд ч гэсэн удамшлын асуудлаас илүү үлдэгдсэн эмэгтэйчүүдийн аюулгүйн байдлыг бүрдүүлэх харилцан туслалцах зарчмыг бодсон нь зүй зохистой гэж бодно. Хаант улсын өргөтгөл нь баатарын хувийн либидо буюу бэлгийн сэрлээр дүгнэж болох асуудал биш. Гэтэл цэвэр цусны үзэлд үндсэрхэх үзлийнхний сэтгэл хөдөлгөх тал байна гэж хэлэхээс өөр аргагүй. Үнэн хэрэгтээ монголын цэвэр цусны асуудал Иноүэ-гээс өмнө нэгэнт японы уран зохиолд гарч байсан. Японоор эзлэгдсэн бүс нутгийн монголчуудыг дүрслэх зохиол, өөрөөр хэлбэл ‘колони орны уран зохиол’ гэсэн салбарт харж болно. Үүний жишээ нь Акүтагава(芥川) нэрэмжит шагналыг хүртсэн Ишизүка Кикүзоо(石塚喜久三,1904-1987)-гийн “Тэнсокү но коро(纏足の頃)” болно. Ишизүкагийнх өөрийнх хоёр зохиолын харьцааны талаар Иноүэ яриагүй боловч далд холбоо харьцаатай байх гэж бодогдох юм. “Тэнсокү но коро” -гийн талаар Кавамүра

Минато(川村湊)-гийн номд нарийвчлан бичсэн учраас энд ярихаа больё. Сонирхосон хүн байвал Кавамүра-гийн номыг үзнэ үү.

Нөгөө талаар, монголчуудыг ингэж түгээмэл дүрсээр зурагласны туйлийн эсрэгийн монгол хүний дүрс бас байна. Тэр Иноүэ мэт ном доторх монгол хүнтэй учирсан биш, үнэн бодьт монгол хүнтэй харилцсанаар бий болсон бүтээл юм. Жишээлбэл Сиберь, Монголд олзлогдсон үед монгол хүнтэй танилцснаар бий болсон. Үүний жишээгээр Хасэгава Широо(長谷川四郎,1909-1987)-гийн “Сибэрийн үлгэр” доторх “Насунбо” гэдэг өгүүллэгээр жишээ татаж болно. Дайны үеэр аз бусаар Халх голын хавиар төөрчихөөд япончуудтай хамт хорих газарт ажиллах болсон монгол малчин томилолтоор явсан Агад оргон дутаасан богино өгүүллэгт Хасэгава Насунбо гэдэг хүнийг орос ч биш, япон ч биш, монгол хүнээр мөн чанаржуулж үзсэн. Өөрсдөө өндөр бахархалтай монголчуудыг гүнээ хүндэтгэсэн зохиол мөн боловч монголчууд та бүхний хувьд гол дүр нь өөртэйгөө адилхан байна гэж арай санагдахгүй байж магадгүй. Энд чухал зүйл бол зохиолч Хасэгава Насунбог өөрийн нэг адил түвшингээс дүрсэлсэн байна гэдэг юм. Тэгээд түгээмэл хүнлэг хүчин зүйлийг төдийгүй, монгол хүний онцлогтой амьдралыг бас дүрслэх гэж хичээсэн билээ. Насунбог өөрөөсөө бусад хүн мөртлөө харилцан ойлголцож болохуйц хүнээр дүрсэлсэн байна. Нэг утгаар соёлын мөн чанарыг үзэх арга бөгөөд хэвэнд оруулахаас хараахан зайлсхийлж чадсан нь Хасэгавагийн өөрийн туршлага болон хүнийг гүнзгийлэн ажиглах чадвараас болсон байх. Хэвэнд оруулах явдлын талаар ярихад Мүраками Харүки(村上春樹,1949-)-гийн зохиолд гарсан монгол хүнийг дурьдахгүй байж болохгүй юм. Мүраками бол одоо зүүн Азийг багтаан дэлхий дахинд нэрд гарсан зохиолч мөн байна. Та бүхэнд түүний фен байж магадгүй бөгөөд би өөрөө нэг үеийнх ба нэг нутгийнх гэсэн хувьд түүний буурь суурьтай уншигчийн нэг нь байна. Гэтэл түүний дүрсэлсэн монголын талаар нэг юм ярихгүй байж болохгүй. Тэр бээр нэг үеийг хүртэл хам утгаас салсан ертөнцийг эрмэлзэж байсан. Тэр болон би америкийн үеийн хүн байхаар үл барам түүнийн америкийн уран зохиолын судалгаа түүний уран зохиолын үндэс суурийг тавьсан гэж хэлж болох байх. Үүний үр дүнд тус зохиолчийн түгээмэл ертөнцийг бий болгох тогтолцоонд монгол хүнийг америкийн олон нийтийн өгүүллэг доторх монгол хүнтэй нэг адилаар хэвэнд оруулчихсан байна. Түүний өгүүллэг доторх монгол хүн бол ойлголцоход маш хэцүү “абусолот бусад субъект”-ээр гарч ирнэ. Хасэгавагийн Насунбо мэт ойлголцож болохуйц дүрсээр үл дүрслэгдсэнгүй. Түүний дүрслэсэн монгол болон монголчуудын дүрс бол Ёсано Акико(与謝野晶子) нарын үеэс үргэлжлэгдсэн японы маягийн ориентализмын цаана байдаг байна гэж хэлж болно. Үүний талаар би нэгэнт өгүүлэл бичсэн. Энэ өгүүлийг веб хуудаст нийтлэсэн учир орж уншна уу. Та бүхний аль нэгэн хүн монголчлох эсвэл хятадчилж болно. Мүраками-гээс эрс ялгаатай, харилцан ойлголцмоор монголыг нэг утгаар хүслэнжүүлэн зурагалж үзүүлсэн нь Шиба Риотароо(司馬遼太郎,1923-1996) байжээ. Шиба гуай манай их сургуулийн дээр ангийн төгсгөгч бөгөөд залуу үед уулзан сургаал,зөвөлгөө авч байсан хүн учраас хүндэтгэн зүй зохистой, шудрага ёсоор, хойч үеийнхэнд зориулан нэгэн өгүүлбэр бичсэн. Одоо тус өгүүлбэрийн гол санаагаа товчхон танилцуулъя. Шиба гуай зохиолчоор нэрд гарахын дагалдан Монголоос салж явах болсон боловч түүний Монголд хандах сэтгэл санаа нь “хэрэв тэд нарын үндэстний сэтгэл гэдгийг бичиж чадвал хэзээ үхсэн ч яахав” гэж хэлдэг түвшинд хүрээд байжээ. 1974 оны “Монголын

замын тэмдэглэл” түүний монголын тухай зохиол дотор хамгийн чухал нэг нь юм. Олон ангит “Каидоо-wo юкү(街道を行く)”-гийн нэг хэсгээр нь Монголын тухай бичих болсонд “Монгол бол мөрөөдлийн доторх улс байжээ” гэж Шиба гуай ярьдаг байсан. Шиба гуай Монгол явахаас өмнө асар их ном уншаад байсан. Санаанд нь нэгэн монгол бий болсон байжээ гэж хэлмээр. Тэгээд Шиба гуай өөрийн санаанд бий болсон монголтой учрахаар явсан байна. Энэ нь маш чухал зүйл гэж би бодно. Жинхэнэ Монголыг мэддэг хүн тус өгүүллэгийг уншихад эвгүй санагдах нь ийм учиртай. Монголыг мэдэхгүй хүний хувьд эвгүй сэтгэгдэл төрөхгүй. Өөрөө хэлбэл ийм хүмүүс Шиба гуайн монголыг жинхэнэ Монгол гэж ойлгож ч магадгүй. Шиба гуай үе үе ярьдаг байсан романтикийн монгол бол Шиба гуайн санаанд бий болсон монгол мөн байна. “Монголын замын тэмдэглэл”-д түүний дурьдсан монгол бол жинхэнэ байдагаараа байдаг Монгол биш, Шиба гуайн нүдээр үзсэн монгол бөгөөд бага сага засвар оруулсан ч санаанд нь бий болсон монгол байна. ‘Мэдээлэлийн уран зохиол’ гэж нэрлэгдсэн бүтээл биш. Санаан доторх монгол нь “Монголын замын тэмдэглэл”-ийн үргэлжлэл гэмээр “Тал нутгийн тэмдэглэл”-д бас олон удаа гарч ирнэ. “Тал нутгийн тэмдэглэл”-д Ямазаки Масаказү(山崎正和)гийн магтааж л байсан ‘Юан улс хойшоо буцсан’-ы нэгэн хэсгийн талаар “Тал нутгийн тэмдэглэл” бичигдсэн үед Монголд янханы газар байсан бөгөөд “Монголын замын тэмдэглэл”-ийн үед ч гэсэн орос хүнд зориулсан, гадаад хүний нүдэнд тусагдмал янханууд байсан учраас сонины сурвалжлагч байсан хүний нүдээр ажиглавал Улаанбаатар зочид буудлын хавьд ч гэсэн олж мэдэх ёстой байжээ. Гэтэл Шиба гуай тийм монгол хүн биш, гайхмаар шунал багатай амьдардаг монголчуудыг хармаар байсан. Иймд Улаанбаатар хотод Өгүдэй шиг хүнийг харлаа. Мэдээж Өгүдэй шиг шунал багатай монгол хүн олон амьдардаг гэдгийг би татгалзахгүй, тийм байгаасай гэж сэтгэлээсээ хүсэж байна. Гэхдээ “Тал нутгийн тэмдэглэл” хэвлэгдсэн дараахан 1994 онд Улаанбаатарт сууж иймэрхүү монгол хүнийг харж чадсангүй. Би “харамсалтай нь багшийн бичсэн мэтийн монгол хүний дүрийг УБ хотод харж чадахгүй байна” гэж захиаг Шиба гуайд бичсэн юм. Шиба гуай зохиолдоо санаан доторх монгол, жинхэнэ Монгол хоёрыг тэнцвэржүүлэхийг мартаагүй. Санаад байгаа монголыг жинхэнэ Монголд ойртуулахын тулд Цэвэгмаа гуайн тухай бичжээ. Жинхэнэ Монголд зуучлагч байсан учир Цэвэгмаа гуайн тухай бичихэд маш анхаарал тавьж байжээ. Энэ нь Шиба гуай жинхэнэ Монголыг сайн ажиглаж байсан гэрч мөн байна. Илүүхэн бичвэл Цэвэгмаа болон түүний тойронд байгаа хүмүүст шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Шиба гуай үүнийг сайн ойлгож байсан бөгөөд өөрийн уран зохиолын төлөө гадаад хүний амьдралд бага сага асуудал үүссэн ч яахав гэж ерөөс бодсонгүй. Цэвэгмаа гуай Читад төрөөд Баргад очиж Баргаас Өвөр монголын төвд, цаашаа УБ хүртэлх явдал мөр нь орчин үеийн хэцүү түүхийг маш сайн бодолхийсэн гэж бодож байна. Тэгвэл жинхэнэ Монголыг сайн ажиглаж байгаад санаанд бий болсон монголыг бичих гээд оролдож байсан нь ямар учиртай юм бол? Энэ нь япончуудын алдсан зүйл, японы энд хүртэл хийж ирсний туйлын эсрэг талд байх зүйлүүдийг дүрслэх хүсэлтэй байсан байх гэж би бодож байна. “Риома-га юкү(竜馬がゆく)”, “Сакано-үэно-күмо(坂の上の雲)” –г бичээд жигшмээр дур хүслээ ний нуугүй илэрхийлдэг хөөрхийлмээр Осака нутгийн хүмүүсээр төлөөлөх орчин үеийн үнэлэмжтэй амьдралдаа зүтгэдэг энгийн ард иргэдэд сэтгэлийн дэмжлэг үзүүлж ирсэн боловч япончууд дэндүү их юм алдсан байна. Үүний туйлын эсрэг талд байгаа Өгүдэй мэтийн монгол хүний дүрийг япончуудад харуулмаар байсан юм байна. ‘Хөдөлмөрлөх баяргүй, тариачин байх бахархал ч үгүй’, шунахай

япончуудад газар эзлэх ойлголтгүй монголын ‘ариун дагшин энгийн байдл’ –ыг харуулж өгмөөр байсан. Энэ гэрч нь амьдралын сүүлийн үед бичсэн эссээдээ Ариан үндэстний гоёо хүүхнийг хайхаар баруу зүгийг зорисон бэлгийн тачаалаар дүүэн монгол хүний оронд Фүжи ууланд хандаж хүж тавих хуучин үеийн сайхан сэтгэлтэй монгол хүн гарч ирэх болсонд харагдаж байна. Иймэрхүү монгол ба монголчуудын дүрийг и255 японы уншигчдад зориулан дүрслэсэн гэж Шиба гуай өөрөө зөвшөөрч байсан. “Тал нутгийн тэмдэглэл”-ийг монголчлохыг хүссэн миний захианд шууд зөвшөөрсөн хариу захианд ‘тус зохиол монгол хүнд сонирхолтой эсэхийг сайн бодоорой’ гэж бичсэн байжээ. Шиба гуай энэ өгүүллэг монголчуудад түгээмэл утга агуулга байх эсэхийг сайн бодоорой гэж надаас асуусан байх гэж бодож байна. Би том алдаа гаргасан. “Нууц товчоон”-ыг анх монголчлосон Цэнд гүнгийн охин Хандсүрэн багшаар монголчлуулах хүсэлт тавьсан. Цэнд гүнгийн эх бичгийг анх хэвлүүлсэн нь манай судлалын дугуйлан байжээ. Хандсүрэн багш Шиба гуайн төсөөлсөнчлөн албан ёсоор зөвшөөргдсөн орчуулагын ажлаа дундаа орхисон байна. Хандсүрэн багш “миний хувьд ямар ч сонирхол байхгүй байсан учраас” гэж эргэцүүлэн ярьсан. Энэ нь аргагүй байсан байна даа. Хандсүрэн багш өөрөө туулж ирсэн амьдралтай харицуулан үзэхэд “Тал нутгийн тэмдэглэл”-ийн гол дүрийн туршлага нь нэг сонирхолгүй энгийн юм шиг санагдсан байлгүй дээ. Зарим наснаас дээшх үеийн монголын уншигчдын хувьд ч гэсэн тийм байх. Эцсийн эцэст тус зохиолыг залуу монгол хүн монголчилж, шагнал хүртсэн. Хандсүрэн багшийн хувьд ойлгомжгүй явдал болсон байх. Харин Шиба гуай үүнийг ойлгож байсан байх гэж бодогдоод байна. Шиба гуайн мөрөөдлийн монгол бол хий мэт гэнэт алга болчихдог. Үүнийг бүтээлдээ тусгаж чадсан нь Шиба, Цэвэгмаа гуайн учрал байсан гэж бодогдоод байна. Цэвэгмаа гуайн амь нас нь Шиба гуайтай уулзсанаар өөрчилөгджээ. Коибүчи гуайн ярьсанчлан түүний ‘зөвхөн хүсэлт бүхий амь нас’ нь ‘үржил шимтэй амь нас’-аар өөрчилөгдсөн байна. Шиба гуай бас Цэвэгмаа гуайтай учирснаар өөрчилөгдсөн байна. Өөрөө нас барахыг ойлгож байсан байх гэж бодогдох үеэр монголын тухай хамгийн сүүлийн бүтээлийн хамгийн сэтгэл татах увдьстай гол дүрээр эхний бүтээлдээ сэтгэл татах хүчээр нохойгоос бага гэж Чингис хаанаар тоолгоогүй монголын эмэгтэйчүүдээс монголын төлөөллийг сонгож авсан байна. “Тал нутгийн тэмдэглэл” бол хоёр сүнс учран харилцсан үлгэр байна. Японы хаант улсын үе, Соёлын хувьсгалын үе, эсвэл Цэдэнбалын үеийн монголын эмгэнэлт түүхийг сонсохоор ясаа тавихын тулд монгол оронд хүрээд ирсэн эцгийнхээ сүүлийн үеийг харж сахисан охин нь эцгийнхээ суралцаж байсан үед гарч байсан гүүрийг и255 явахад төрсөн сэтгэгдлийг сонсоод илүү олон юм санагддаг биш үү? Шиба гуайн зурагласан мөрөөдлийн монгол хүн байхгүй гэж гомдож байсан тийм байдалтай Монголд би Нацагдоржийн Анандширтэй уулзсан. Юмны учрыг ухаарахаас өмнө Монголоос Ленинград дагуулан явчихаад зарим үед монгол, зарим үед орос хүнээр хандагдан, Зөвлөлт холбоот улсыг задарсаны дараа өвдөөд үндсэрхэх үзлийн шуургатай Эстони улсаас амьдралын сүүлийн үеийн газар гэж шийдсэн эцгийнхээ нутагт буцаж ирээд хэнээс ч харж сахиулахгүйгээр нас барсан монголын уран зохиолын эцэг Нацагдоржийн охин Анандшир. Түүний ширүүн нэгэн нас нь Хандсүрэн багш болон Цэвэгмаа гуайнхтай адилхан санагсан юм. Шиба гуайнх мэт уран зохиолын анхилга багатай ч гэсэн миний бичсэн Анандширийн үлгэр бас япон хүний бичсэн монгол хүний нэг нь байж магадгүй. Шиба гуайгаас залгамжилж авсан юм бол хам утгаас салгасан хийсвэр хүмүүст хандах үзэл бодол биш бөгөөд түүх, соёл, амьдрал зэргийн хам утгатай байгаа хувь хүнийг гүнзгий ойлголцох сэтгэл байна. Сүнсээр учран

танилцаж, харилцан ойлголцох замаар ерөөс ойлгомжгүй болгох хандлага, хэвэнд оруулах явдлыг даван туулж болно гэж бат итгэж байна. Өгүүллэгээс бусад, жишээлбэл зурагт ном, комик ном, кино, тоглоом гэх мэтийн салбарт зурагласан монгол хүний дүрсийн тухай бас дурьдъя гэж бодож байсан боловч цаг болсон байна. Цаашид олон янзын харилцаа солилцоогоор дамжуулан, Япон болон бүх монгол нутгийн хүмүүсийн хооронд харилцан ойлголцох явдал дэлгэрээсэй гэж хүсэн ерөөж, үүгээр миний өчүүхэн итгэлээ өндөрлөе.

Summary

This paper explores how the writers in Japan describe Mongolian people in their literary works.

First, I explain the emergence of a popular image of Genghis Khan in Japan, which was created by Inoue Yasushi (1907-1991) in his historical novel *Aoki Okami*, inspired by *The Secret History of the Mongols* translated by Naka Michiyo (1851-1908).

Second, I focus on the difference between the image of Mongols by Hasegawa Shiro (1909-1987) and that by Murakami Haruki (1949-), which is a typical example of a Mongol as an object of Japanese Orientalism under the influence of discourses in the Occident.

Lastly, through the analysis of the novels by Shiba Ryotaro (1923-1996), this paper presents the possibility of mutual understanding between the Japanese and the Mongols.